



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/006/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2025 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК  
Захирал: Б.Ариунаа  
Утас: 99168735 Цахим хаяг: [arifin.audit@gmail.com](mailto:arifin.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	12
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. Аудитын илрүүлэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025-03-14 № СЭА-2025/006/НА-СТА-ОНӨҮГ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ӨРГӨН СЭЛЭНГЭ ҮЙЛЧИЛГЭЭ”  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Э.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.2, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Байгалийн үзэсгэлэнт цогцолбор газар Сайханы хөтлөөр аялах иргэдээс авч буй хураамжийн тасалбарыг дугаарлаж, баримтжуулаагүй, төлбөрийн цахим баримт олгодоггүй, үнэт цаасны тооцоо хийдэггүй зэргээр анхан шатны баримтын бүрдэл дутуу 93,880.0 мянган төгрөгийн орлогын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,

- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тус үйлдвэрийн газрын үйл ажиллагааны орлого бус аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нөөцийн махны борлуулалтын орлогыг татварын өрөнд суутгуулсан 52,978.1 мянган төгрөг, авлага барагдуулсан 12,676.8 мянган төгрөг зэрэг нийт **65,654.9** мянган төгрөгийг махны нөөцийн дансанд төвлөрүүлээгүй,
- Тус газрын нийт орлогын 40.0 гаруй хувийг бүрдүүлж буй “Олон улсын худалдааны төв” -ийн 1м2 лангууны сарын түрээсийн төлбөрийг аймгийн ИТХ-ын 2017 оны 23 дугаар тогтоолоор баталсан өвлийн улиралд 23.7 мянган төгрөгөөр, зуны улиралд 12.5 мянган төгрөгөөр тооцон түрээсэлж байгаа бөгөөд халаалт дулаан, гэрэл цахилгаан, хэрэглээний ус зэрэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд материаллаг хэмжээгээр нэмэгдсэн нөхцөлд түрээсийн орлогыг бодит байдалд үндэслэн нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж, холбогдох байгууллагуудад санал хүргүүлээгүй,
- Нийт авлагад дүн шинжилгээ хийж барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй, өмнөх онд үүссэн махны нөөцийн 18,622.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн актаас **5,945.9** мянган төгрөгийг барагдуулаагүй буюу нөхөн төлбөрийн актыг бүрэн биелүүлээгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 593,169.6 мянган төгрөгийн өртөгтэй “Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх” ажлыг Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 391 дүгээр албан бичгийн дагуу бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд нийт 1,326,136.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,254,356.0 мянган төгрөгийн зарлага гарган 71,780.0 мянган төгрөгийн ашигтай ажиллагааг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 1,329,263.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,809,641.0 мянган төгрөгийн зардал гарган, 392,179.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгдсэн байна.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	34,465,861.56	36,197,481.66
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	9,921,443.22
1.1.4	Бусад авлага	118,335,342.50	96,824,831.87
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		-
1.1.6	Бараа материал	449,898,361.50	426,383,838.47
<b>1.1.20</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>602,699,565.56</b>	<b>569,327,595.22</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,593,635,632.35	7,781,380,401.12
1.2.2	Биет бус хөрөнгө	285,476,696.63	286,860,029.99
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<b>7,879,112,328.98</b>	<b>8,068,240,431.11</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,481,811,894.54</b>	<b>8,637,568,026.33</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,236,337.95	19,869,957.92
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	242,653,161.50	170,599,111.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг		9,186,631.32
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	<b>244,889,499.45</b>	<b>199,655,700.68</b>
<b>2.2</b>	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>244,889,499.45</b>	<b>792,825,328.68</b>
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,922,786,858.72	11,515,956,486.72
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,685,864,463.63)	(3,078,044,161.07)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>8,236,922,395.09</b>	<b>7,844,742,697.65</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,481,811,894.54</b>	<b>8,637,568,026.33</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,251,423,338.18	1,329,263,500.21
	Бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлого	1,251,423,338.18	1,329,016,980.21
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		246,520.00
2	Борлуулалтын өртөг	70,796,575.71	8,890,536.37
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>1,180,626,762.47</b>	<b>1,320,372,963.84</b>
5	Хүүний орлого	324,997.98	134,631.16
9	Борлуулалт, маркетингийн зардал		123,525,207.47
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,762,687,959.22	1,546,575,081.29

12	Бусад зардал	2,039,759.00	7,383,900.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		35,189,640.57
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(583,775,957.77)</b>	<b>(392,166,234.33)</b>
19	Орлогын татварын зардал	3,559.15	13,463.11
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(583,779,516.92)	(392,179,697.44)
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(583,779,516.92)</b>	<b>(392,179,697.44)</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(583,779,516.92)</b>	<b>(392,179,697.44)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	10,816,142,859.02	(2,102,084,946.71)	<b>8,714,057,912.31</b>
3	Залруулсан үлдэгдэл	10,816,142,859.02	(2,102,084,946.71)	8,714,057,912.31
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(583,779,516.92)	<b>(583,779,516.92)</b>
6	Өмчид гарсан өөрчлөлт	106,643,999.70		<b>106,643,999.70</b>
9	2024 оны 01 -р сарын 01 - ний үлдэгдэл	<b>10,922,786,858.72</b>	<b>(2,685,864,463.63)</b>	<b>8,236,922,395.09</b>
11	Залруулсан үлдэгдэл	10,922,786,858.72	(2,685,864,463.63)	8,236,922,395.09
14	Өмчид гарсан өөрчлөлт	593,169,628.0		593,169,628.0
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(392,179,697.44)	<b>(392,179,697.44)</b>
17	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	<b>11,515,956,486.72</b>	<b>(3,078,044,161.07)</b>	<b>8,437,912,325.65</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,283,249,677.00	1,451,437,158.17
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	835,249,677.00	800,182,258.17
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	448,000,000.00	651,254,900.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,247,278,955.24</b>	<b>1,437,390,669.19</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	296,710,583.35	312,941,828.82
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	94,249,693.44	76,071,360.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	161,659,260.60	271,779,001.78
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	352,899,499.08	440,384,524.13
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	147,513,559.72	50,270,473.23
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	164,959,427.79	235,751,050.90
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	222,600.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	29,064,331.26	50,192,430.29
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>35,970,721.76</b>	<b>14,046,488.98</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		

2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,383,597.98	134,631.16
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,058,600.00	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	324,997.98	134,631.16
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,599,999.70	12,449,500.04
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,599,999.70	12,449,500.04
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,216,401.72)	(12,314,868.88)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,754,320.04	1,731,620.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,711,541.52	34,465,861.56
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,465,861.56	36,197,481.66
	БЦМГ(1.3+2.3+3.3+4)	27,754,320.04	1,731,620.10
	БЦМГ(6-5)	27,754,320.04	1,731,620.10
	Зөрүү	-	0.00

## 2.5 Эдийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
	<b>I. НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,326,136.0</b>	<b>1,329,644.6</b>	<b>3,127.5</b>	<b>100.2</b>
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	674,881.8	727,684.9	52,803.1	107.8
2	Татаас санхүүжилтээс	651,254.9	601,578.5	(49,676.4)	92.4
3	Бусад орлого		381.2	381.2	
4	<b>II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>				0.0
5	<b>IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,254,356.0</b>	<b>1,809,641.0</b>	<b>555,285.0</b>	<b>144.0</b>
7	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	368,868.0	367,021.0	(1,847.0)	99.5
12	Ажил олгогчоос	44,365.6	45,610.7	1,245.1	102.8
	<b>Удирдлага зардал</b>	5,000.0	4,740.9	(259.1)	94.8
14	Бичиг хэрэг	2,864.4	2,148.9	(715.5)	75.0
15	Гэрэл цахилгаан	302,000.0	345,668.1	43,668.1	114.5
16	Түлш, халаалт	58,835.6	73,835.6	15,000.0	125.5
17	Тээвэр (шатахуун)	51,747.6	50,270.5	(1,477.1)	97.1
18	Шуудан, холбоо, интернет	3,600.0	3,483.1	(116.9)	96.8
19	Ариутгал, цэвэрлэгээ	14,200.0	13,429.0	(771.0)	94.6
20	Цэвэр, бохир ус	21,600.0	40,861.8	19,261.8	189.2
21	Дотоод албан томилолт	3,000.0	2,232.0	(768.0)	74.4
23	Мэргэжлийн үйлчилгээний зардал	10,335.1	10,250.0	(85.1)	99.2
24	Гэрэлтүүлгийн сэлбэг хэрэгсэл	68,778.9	68,778.0	(0.9)	100.0
25	Тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл	21,477.2	21,470.0	(7.2)	100.0
28	Материал хангамж	62,121.1	62,121.0	(0.1)	100.0
29	Урсгал засвар	78,000.0	76,333.7	(1,666.3)	97.9
30	Даатгал зардал	500.0	475.4	(24.6)	95.1
31	шагнал урамшуулал	5,000.0	4,400.3	(599.7)	88.0
32	Төлбөр хураамж болон бусад зардал	172.0	215.0	43.0	125.0
33	Сургалт зардал	400.0	150.0	(250.0)	37.5
34	Хандив тусламж	2,500.0	2,275.0	(225.0)	91.0
36	Татвар төлөлт	139,325.2	235,751.0	96,425.8	169.2
	Элэгдлийн зардал	-	388,369.9	388,369.9	0.0
	ББӨ	-	8,890.6	-	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ нь “Сүхбаатар сумын ард иргэдийг тэгш хүртээмжтэй, соёлч боловсон, түргэн шуурхай үйлчилгээгээр ханган ажиллах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Худалдааны төвийн тохижилт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх, хяналт тавих, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд зарцуулалт хийх, үр ашигтай ажиллуулах,
- Худалдааны төвд үйл ажиллагаа явуулах иргэн, байгууллагатай гэрээ хийх, байр талбайг ашиглуулах, ашиглалтын төлбөр тооцоог хийх,
- Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслээр аймгийн төвд эрх бүхий байгууллагын тогтоосон чиглэл, хуваарь, үнэ тарифаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх, төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг тогтоосон үнэ тарифаар үзүүлэх,
- Орон нутгийн өмчийн мал нядалгааны цэг, махны хөргүүрт зоорины ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх,
- Эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрийн дагуу аймгийн махны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, түгээх ажил үйлчилгээг эрхлэх,
- Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, төлөөлөн хэрэгжүүлэгч нь сумын Засаг дарга байх бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2022 оны 38 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 30-нд нэмэлт өөрчлөлт орсон, гэх мэт.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Сүхбаатар сумын ИТХ, ЗДТГ-аас төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд "Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 155,756.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,465.8	36,197.5	1,731.7

Авлага	118,335.3	106,746.2	-11,589.1
Бараа материал	449,898.4	426,383.8	-23,514.6
Үндсэн хөрөнгө	7,879,112.3	8,068,240.5	189,128.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,481,811.8</b>	<b>8,637,568.0</b>	<b>155,756.2</b>
Өр төлбөр	244,889.4	199,655.7	-45,233.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,236,922.4	8,437,912.3	200,989.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,481,811.8</b>	<b>8,637,568.0</b>	<b>155,756.2</b>

Дээрхи хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 36,197.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,731.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 1,451,437.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, 1,449,705.5 мянган төгрөгийн зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 106,746.2 мянган төгрөг болж 11,589.1 мянган төгрөгөөр буурсан нь ажилчдаас авах авлага 8,468.2 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 2,870.0 мянган төгрөг нийт 11,338.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, түрээсийн авлага 11,858.1 мянган төгрөг, нөөцийн махны авлага 11,069.2 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 426,383.8 мянган төгрөг болж 23,514.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 309,697.6 мянган төгрөгийн бараа худалдан авч, 333,212.1 мянган төгрөгийн бараа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,068,240.5 мянган төгрөг болж 189,128.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 11,564.3 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшил худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 593,169.6 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, төслөөр нийлүүлэгдсэн 8,181.8 мянган төгрөгийн хог пресслэгч машиныг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар тогтоолоор 60,888.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 362,670.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 199,655.7 мянган төгрөг болж, 45,233.7 мянган төгрөгөөр буурсан нь татварын өрийг төлсөнтэй холбоотой байна

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, биелүүлэлтийг хангах үүрэгтэй.

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж, тайлант оны нийт орлогыг 1,326,136.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 1,254,356.0 мянган төгрөгөөр, үйлдвэрлэлийн үр дүнг 71,780.0 мянган төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,329,263.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,809,641.0 мянган төгрөгийн зардал гарган, 392,179.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт орлогын гүйцэтгэл 1,329,263.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 3,127.5 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар давж биелэсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,809,641.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 555,285.0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь элэгдлийн зардлыг зардлын төлөвлөгөөнд нэмж тусгаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагаагаар 31,263.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан боловч 35,189.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгө акталж, үндсэн хөрөнгийн гарз үүссэн болон тайлант оны үндсэн хөрөнгийн 388,253.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалан 392,179.7 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот тувшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари фاینэнс аудит” ХХК-ийн ахлах аудитор Г.Эрдэнэмөнх, аудитор Б.Туяа нар гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг гүйцэтгэж, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлангаа “Ари фاینэнс аудит” ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/48 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,835,524.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 27,532.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 27 төрлийн 170 мэдээллийг байршуулахаас 2 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээлэл:

- Төсвийн гүйцэтгэл
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Огт мэдээлээгүй мэдээлэл:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файл-шийдвэрийн хуулбар,
- Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /тухай бүр/,

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт, 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудагт мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

“Өргөн Сэлэнгэ” ОНӨААТҮГ нь нөөцийн мах болон шатахууны худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу [tender.gov.mn](http://tender.gov.mn)-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Нөөцийн мах	80,030.9	62,721.8	Харьцуулалтын аргаар
2	Шатахуун	40,000.0	-	Харьцуулалтын аргаар
	<b>Нийт дүн</b>	<b>120,030.9</b>	<b>62,721.8</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах шатахуун худалдан авах сонгон шалгаруулалтад Сод Монгол ХХК шалгаран гэрээ байгуулсан бол нөөцийн махны тендерийг 2 удаа зарласан боловч оролцогч ирээгүй байна.

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 18,622.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган шалгахад 96.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

#### Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	18,622.7	1	11,067.8	59.4
Албан шаардлага	3	143,363.8	3	143,363.8	100.0
Зөвлөмж	4	29,548.8	4	29,548.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>191,535.3</b>	<b>8</b>	<b>183,980.4</b>	<b>96.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхааах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 5.1 Залруулга

Аудитаар нийт **890,683.1** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тайлант оны үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдлийг 285,384.0 мянган төгрөгөөр илүү, биет бус хөрөнгийн эхний үлдэгдлийг 285,384.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- Татварын өглөгийн дансны эхний үлдэгдлийг 1,995.2 мянган төгрөгөөр дутуу, урьдчилж орсон орлогын дансыг 1,995.2 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.
- Тайлант оны жилийн эцсээр Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар 9,186.6 мянган төгрөгийн өглөгтэй байгаа боловч санхүүгийн байдлын тайлан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

дахь Нийгмийн даатгалын өглөг дансанд 7,234.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу 1,952.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.

- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 593,169.6 мянган төгрөгийн гэрэлтүүлгийг урьдчилсан орсон орлогоор бүртгэснийг эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бүртгүүлсэн,
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх 8,181.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Аудитаар нийт **260,748.7** мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах 165,480.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 95,267.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

## 5.1 Албан шаардлага

1. Байгалийн үзэсгэлэнт цогцолбор газар Сайханы хөтлөөр аялах иргэдээс авч буй хураамжийн тасалбарыг дугаарлаж, баримтжуулаагүй, төлбөрийн цахим баримт олгодоггүй, үнэт цаасны тооцоо хийдэггүй зэргээр анхан шатны баримтын бүрдэл дутуу 93,880.0 мянган төгрөгийн орлогын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хураамжийн тасалбарыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангасны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, орлогын бүрдүүлэлтэд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тус үйлдвэрийн газрын үйл ажиллагааны орлого бус аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нөөцийн махны борлуулалтын 52,978.1 мянган төгрөгийг татварын ерөнд суутгуулсныг нөхөн тооцож болон нөөцийн махны борлуулалтын авлагаас төвлөрүүлсэн 12,676.8 мянган төгрөг зэрэг нийт **65,654.9** мянган төгрөгийг махны нөөцийн дансанд төвлөрүүлээгүй бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтад санал ирээгүй гэх үндэслэлээр 2024 онд махны нөөц бүрдүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх “Захирал дараах эрх үүрэгтэй”, 20.1.2: “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах” гэсэн заалт болон тус үйлдвэрийн газрын дүрэмд заасан “Эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрийн дагуу аймгийн махны нөөцийг бүрдүүлэх,

хадгалах, түгээх ажил үйлчилгээг эрхлэх” гэсэн үйл ажиллагааны чиглэлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Махны нөөц бүрдүүлэх зориулалтаар төсвөөс санхүүжүүлсэн эх үүсвэрийг холбогдох дансанд нь төвлөрүүлж, үйл ажиллагааны чиглэлийн дагуу аймгийн махны нөөц бүрдүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Өмнөх аудитаар өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үр дүн, үр нөлөөтэйгөөр удирдан зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." гэсэн гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Тус газар нь нийт орлогын 40.0 гаруй хувийг бүрдүүлж буй "Олон улсын худалдааны төв" -ийн 1м<sup>2</sup> лангууны сарын түрээсийн төлбөрийг аймгийн ИТХ-ын 2017 оны 23 дугаар тогтоолоор баталсан өвлийн улиралд 23.7 мянган төгрөгөөр, зуны улиралд 12.5 мянган төгрөгөөр тооцон түрээсэлж байгаа бөгөөд халаалт дулаан, гэрэл цахилгаан, хэрэглээний ус зэрэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд материаллаг хэмжээгээр нэмэгдсэн нөхцөлд түрээсийн орлогыг бодит байдалд үндэслэн нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж, холбогдох байгууллагуудад санал хүргүүлээгүй,
- Авлагын үлдэгдэлд дүн шинжилгээ хийж барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй, өмнөх онд үүссэн махны нөөцийн 18,622.7 мянган төгрөгийн авлагаас 5,945.9 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бодит байдалд үндэслэн түрээсийн төлбөрийг нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлэх, түрээсийн төлбөрийн болон махны нөөцийн авлагыг барагдуулах, шаардлагатай бол хууль, хяналтын байгууллагуудад шилжүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх.

## 5.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Өглөгийн данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлол"-д татварын өглөгийг 21,124.6 мянган төгрөгөөр дутуу, авлагыг 23,840.0 мянган төгрөгөөр илүү тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5

дахь” Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:** Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнах,

## **2. Шатахууны зарцуулалттай холбоотой**

**2.1 Илрүүлэлт:** Тайлант онд зарцуулсан 50,303.3 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог норм нормативаар тооцож бодоогүй, жолоочийн авсан дүнгээр зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь” Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”, Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тушаал “100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Шатахууны 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтыг норм нормативаар нь тооцож, жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог бодож байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

# 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Тайлант оны үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дансны эхний үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн.	1	284,384.0			1	284,384.0	1	284,384.0					
Татварын ер дансны болон , урьдчилж орсон орлогын дансны эхний үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн.	1	1,995.2			1	1,995.2	1	1,995.2					
Жилийн эцсийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон санхүүгийн байдлын тайлан дахь өглөгийг зөрүүтэй бүртгэсэн.	1	1,952.5			1	1,952.5	1	1,952.5					
Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн гэрэлтүүлгийг урьдчилсан орсон орлогоор бүртгэснийг эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бүртгүүлсэн	1	593,169.6			1	593,169.6	1	593,169.6					
Үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.	1	8,181.8			1	8,181.8	1	8,181.8					
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>890,683.1</b>			<b>5</b>	<b>890,683.1</b>	<b>5</b>	<b>890,683.1</b>	<b>5</b>	<b>890,683.1</b>	<b>5</b>	<b>890,683.1</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сайханы хөтлөөр аялах иргэдээс авч буй хураамжийн тасалбарыг дугаарлаж, баримтжуулаагүй, төлбөрийн цахим баримт олгодоггүй, үнэт цаасны тооцоо хийдэггүй зэргээр анхан шатны баримтын бүрдэл дутуу орлогын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	93,880.0			1	93,880.0						
Махны нөөцийн борлуулалтын орлогыг холбогдох дансанд төвлөрүүлээгүй, 2024 онд махны нөөц бүрдүүлээгүй.	1	65,654.9			1	65,654.9						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	5,945.9			1	5,945.9						
Шатахууны зарцуулалтыг норм нормативаар зарцуулалтын тооцоог бодоогүй	1	50,303.3								1	50,303.3	
Татварын тодорхойлолтоор 21,124.6 мянган төгрөгийн дутуу, 23,840.0 мянган төгрөгийн илүү тусгасан байна.	1	44,964.6								1	44,964.6	
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>260,748.7</b>			<b>3</b>	<b>165,480.8</b>			<b>2</b>	<b>95,267.9</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>												
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2 мэдээллийг хугацаа хоцроон, 2 мэдээллийг 2 огт мэдээлээгүй байна.	1	-										1
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>							<b>1</b>			<b>-</b>